

“ТЕРМЕС ЦЕНТР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛ
ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ЖУРАМ



Нэг. Ерөнхий зүйл

1. Энэхүү журмын зорилго нь “Термес центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, тухайн жилийн хувьцаа эзэмшигчдийн хурлын ажиллах дэг, журмыг тогтооход оршино.

Хоёр. Хувь нийлүүлэгчдийн хурал

1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурал байна. Хувь нийлүүлэгчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.
2. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг жил бүрийн 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор ТУЗ тухайн жилийн 4 сарын 1-ний өдрийн өмнө зарлан хуралдуулна.
3. Тухайн жилийн 4 сарын 1-ний өдрөөс өмнө зарлан хуралдуулаагүй бол ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болж, хурал зарлан хуралдуулах эрх Хяналтын Зөвлөлд шилжинэ. Хяналтын Зөвлөл нь бүрэн эрх шилжсэнээс хойш 15 хоногийн дотор ээлжит хурлыг зарлан хуралдуулна. Хяналтын Зөвлөл энэ үүргээ биелүүлээгүй бол компанийн хувь нийлүүлэгчийн аль нэг нь хурал зарлах эрхтэй болно. Энэ тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хурал зарлах, хуралдуулах зардлыг компани хариуцна.
4. Хувь нийлүүлэгчдийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдан явуулна. Компанийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг эзэмшиж буй хувь нийлүүлэгчийн саналаар хурлын даргыг сонгох асуудлыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож буй саналын эрхтэй гишүүдийн олонхийн саналаар сонгож болно.
5. Шаардлагатай тохиолдолд ТУЗ, эсвэл саналын эрхийн 10-с дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчийн санаачилгаар ээлжит бус хурлыг “Компанийн тухай хууль”-д заасны дагуу хуралдуулж болно.
6. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн батална. Үүнд :
 - 6.1. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах
 - 6.2. Компанийг өөрчлөх, нэгдэх, хуваах, өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах
 - 6.3. Компанийг татан буулгах, татан буудаг комиссыг томилгох
 - 6.4. Хувьцааг хуваах, нэгтгэх
 - 6.5. Компанийн өрийг хувьцаагаар солих
 - 6.6. ТУЗ-ийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь дуусгавар болгох
 - 6.7. Хяналтын Зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь дуусгавар болгох
 - 6.8. Компанийн үйл ажиллагааны талаарх тухайн жилийн тайланг хэлэлцэн батлах
 - 6.9. ТУЗ болон ХЗ-ийн гишүүдийн цалин хөлсийг тогтоох
 - 6.10. ТУЗ-ийн шийдвэрээр хувь нийлүүлэгчдийн хуралд хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал

Гурав. Хурлын бүртгэл

1. Хуралд нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна.
2. Хурлын бүртгэлийг хурал зарласан өдрөөр бүртгэн авна
3. Саналын эрхтэй хувьцааны 70-с дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Энд заасан хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж дахин хуралдах өдрийн товыг товлөж энэ тухай протокол үйлдэн ТУЗ-ийн дарга баталгаажуулна.
4. Саналын эрхийн 50-с дээш хувийг эзэмшигчид оролцсоноор хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно.
5. Хойшлогдсон хурлыг ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Хойшлогдсон хурал хуралдахаас ажлын 7 ба түүнээс дээш хоногийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.
6. Хойшлогдсон хуралд бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй.